| | |
|---|---|
| ГЕН 2.5. | Бараа нийлүүлэх газар:<br>***“Батгэгээн хангай”ХХК*** |
| ГЕН 2.6. | Бараа нийлүүлэх хугацаа:<br>***2022 оны 09-р сарйн 01-нээс 2022 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд*** |
| ГЕН 2.10. | Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:<br>***Нийлүүлэгч тал чанарын шаардлага хангасан барааг хүлээлгэн өгөхдөө зарлагын баримт бичиг ( хүлээлцсэн акт) үйлдэнэ.*** |
| ГЕН 2.14. | Баглаа, боодол:<br>***Бүтээгдэхүүний багалаа, боодлын бүрэн бүтэн байдлыг шалгаж, хадгалах хугацааг сайн шалгаж, барааг нийлүүлэх*** |
| ГЕН 2.17. | Худалдааны нөхцөл:<br>***[Тендерийн баримт бичгийн ТШЗ 20.6-ийн дагуу ТӨХ-д заасан бол Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хуулж бичих]*** |
| ГЕН 3.8. | *Үнийн тохируулга хийх аргачлал:*<br>***“Ажиллах хүч болон материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгчид төлөх үнийг дараах томьёог ашиглан тохируулна:***<br>$\Delta P = P_0 \left( a + b \frac{L_1}{L_0} + c \frac{M_1}{M_0} \right) - P_0$<br>***Үүнд:***<br>***$\Delta P$ -нийлүүлэгчид төлөх нэмэгдэл үнэ***<br>***$P_0$-гэрээний үндсэн үнэ;***<br>***a -гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн. Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;***<br>***b -гэрээний үнэд ажиллах хүчний эзлэх хувь;***<br>***c -гэрээний үнэд материалын эзлэх хувь;***<br>***$L_0$-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчний өдрийн индекс;***<br>***$L_0$, $L_1$ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчний суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс;***<br>***$M_1$ $M_0$ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн барааны суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс.***<br>***[захиалагч a, b, c итгэлцүүрүүдийг тендерийн баримт бичигт заана. Энэ гурван итгэлцүүрийн нийлбэр дүн аль ч тохиолдолд нэг (1) байна.]***<br>***Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.*** |

120

| | |
|---|---|
| | ***Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.***<br>***Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [2][1] долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно).***<br>***Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд үнийг тохируулах санал гаргах эрхтэй. Үүнд:***<br>***1. Гэрээний суурь үнийг зах зээлийн үнийн судалгаа авч үнийг тохируулна.***<br>***2. Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлүүлэх анхны хуваариас хоцорч нийлүүлсэн хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Нийлүүлэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ буурах үнийн тохируулгыг захиалагч эдгээр хугацаанд хийж болно.***<br>***Гэрээний үнийн /$P_0$/ валют, ажиллах хүч болон материалын индекс нь гарал үүслийн улсын валютаас өөр байх тохиолдолд, гэрээний үнийн тохируулалт буруу хийгдэхээс урьдчилан сэргийлж, залруулах итгэлцүүрийг ашиглана. Залруулах итгэлцүүр нь тус хоёр валютын суурь өдөр болон үнэ тохируулах өдрийн ханшны харьцаа байна.*** |
| ГЕН 3.9. | Төлбөр төлөх хугацаа: ***Сар бүрийн эцэст сурагчдын ирцийн тооцооны хуудас, нэхэмжлэлийн баримт бичгийг үндэслэл болгон төлбөрийг шилжүүлнэ.*** |
| ГЕН 4.2. | Даатгал:<br>***[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]*** |
| ГЕН 4.10. | Баталгаат хугацаа:<br>***[Баталгаат хугацаа заана. ]*** |
| ГЕН 4.11 | Чанарын баталгаа:<br>Чанарын баталгаа шаардах эсэх: ***[Чанарын баталгаа шаардана.]***<br>***Чанарын баталгаа шаардах бол,***<br>Чанарын баталгааны дүн:***[Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь байхаар бичих]*** |
| ГЕН 4.17. | Нийлүүлэгчийн төлөх алданги:<br>Алданги тооцох эсэх: ***[“Тийм”]***<br>Алдангийн хувь: ***[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]*** |
| ГЕН 4.18. | Захиалагчийн төлөх алданги:<br>Алданги тооцох эсэх: [“Тийм”]<br>Алдангийн хувь: ***[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]*** |

[1]Захиалагч шаардлагатай долоо хоногийн тоог заана.